



**ХЭНГИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 5/22

Чингис хот

Х.Болоргэрэлийг ажлаас чөлөөлж,
тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.1, 30 дугаар зүйлийн 30.1, Засгийн газрын 2004 оны 112 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгмийн бодлогын хэлтсийн Хүн ам зүйн нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн бодлого хариуцсан мэргэжилтэн Х.Болоргэрэл нь эрүүл мэндийн шалтгаанаар цаашид ажиллах боломжгүй болсон тул 2018 оны 3 дугаар сарын 09-ний өдрөөр дуусгавар болгон ажлаас чөлөөлсүгэй.

2. Х.Болоргэрэлд албан тушаалын 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгосугай.

3. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:	Г.Лхагвахатан	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд:	Ж.Цэнджав	Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Т.Бямбадулам	Архив, бичиг хэргийн эрхлэгч
	Т.Баяртуяа	Нярав

4. Х.Болоргэрэлтэй эд хөрөнгийн тооцоог хийж дуусгахыг нярав /Т.Баяртуяа/-т, ажилласан хугацааны цалингийн болон бусад тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР